



**АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

**Коронавируст халдвар (КОВИД-19)-тай  
иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх  
түр журам батлах тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх түр ор дэлгэх тухай” А/405 дугаар тушаал, “Шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” А/33 дугаар тушаал, “Түр заавар шинэчлэн батлах тухай” А/36 дугаар тушаал, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрмийн 5.5 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус эмнэлгийн Коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан жирэмсэн, төрөх, төрсний дараах эх нярай, эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний орны тоог нэгдүгээр, Коронавируст халдвар (Ковид-19)-ын Хяналт зохицуулалт, эмнэлгийн тусламжийн багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан жирэмсэн, төрөх, төрсний дараах эх нярай, эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах түр журмыг гуравдугаар, тусгаарлан эмчлэх хэсгийн зохион байгуулалтын ерөнхий зураглалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг эмнэлзүй эрхэлсэн дэд зөхирал /С.Ганболд/, Эрүүл мэндийн чанар аюулгүй байдлын албаны дарга /Ш.Хангал/ нарт, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эмнэлгийн тусламжийн багийн ахлагч, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан /Ө.Сүрнээ/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Амаржих газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/19 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Ц.БАТБОЛД